



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/214

Улаанбаатар хот

Гишүүний эрхийг түдгэлзүүлэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, Гишүүнчлэлийн журмын 5 дугаар зүйлийн 5.2.4.1, 5.2.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:


1. Гишүүнчлэлийн журам болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй хавсралтад дурдсан нэр бүхий 4 үнэт цаасны компанийн гишүүний эрхийг 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн 3 сарын хугацаагаар түдгэлзүүлсүгэй.
2. Гишүүний эрхийг түдгэлзүүлсэн хугацаанд журам болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд гишүүнээс хасах болохыг анхааруулсугай.
3. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газрын Хяналт шинжилгээний алба /Д.Баттулга/-нд үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.АЛТАЙ

"МХБ" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын
2017 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн
А/14 дугаар тушаалын хавсралт



**Гишүүний эрхийг түдгэлзүүлэх арга хэмжээ
авах гишүүн үнэт цаасны
компаниудын нэрс**

1. "Батс ҮЦК" ХХК
2. "Ди Си Эф" ХХК
3. "Догсон" ХХК
4. "Эф Си Икс ҮЦК" ХХК